



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 115

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тус бүр нь 49,500,495 (дөчин есөн сая таван зуун мянга дөрвөн зуун ерэн тав) төгрөгийн балансын үнэтэй, 40,425,404.25 (дөчин сая дөрвөн зуун хорин таван мянга дөрвөн зуун дөрвөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 09-20 ДУН, 09-24 ДУН улсын дагаартай MMI.MON-30S маркийн бага оврын эко автобусыг хавсралтын дагуу Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Хүмүүнлэг, Мандал сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр.Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах), Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Хүмүүнлэг сургуулийн захирал (Д.Мөнхбат), Мандал сургуулийн захирал (М.Энхбаяр) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг сум болон байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

Гурав.Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Дөрөв.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын
20-ны өдрийн 115 тогтоолын хавсралт



ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			сери	дугаар			арлын дугаар	моторын эзлэхүүн				
1	Бага оврын автобус	MMI.MO N-30S	ДУН	09-24	2019	2020/8/7	MU9SSMD4XLE937 015	325.D		49,500,495.00	9.075.090.75	40.425.404,25
2	Бага оврын автобус	MMI.MO N-30S	ДУН	09-20	2019	2020/8/7	MU9SSMD4XLE937 016	325.D		49,500,495.00	9.075.090.75	40.425.404,25
ДУН										99.000.990 /ерэн есөн сая есөн зуун ерэн төгрөг/		80.850.808,5 /наян сая найман зуун тавин мянга найман зуун найман төгрөг таван мөнгө/